

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn

Аудитор: О.Энхтөр

Утас: 95343496 Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

ГАА-2026/001/НА-СТА-ТТЗ

0



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 25

№

157

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнөөс хадгаламжийн хүүгийн орлого 15.9 сая төгрөгөөр тасарсан,
- Өмнөх аудитаар өгсөн 2023 оны 01/73, 02/73, 03/73 дугаартай төлбөрийн акт, 2025 оны 01/172, 02/172 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй үлдэгдэлтэй,
- Тосгоны захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 15.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны

ДЭЛГЭР СУМЫН ГУУЛИН
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ Н.АМАРБААТАР
ТАНАА

822511000454

A/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсвийн орлогыг 205.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 211.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 5.5 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар давуулан биелүүлжээ.

Тайлант онд аймгийн төсвөөс 320.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны өр төлбөрийн үлдэгдэл 20.0 сая төгрөг байна. Захирагчийн ажлын алба 0.2 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургууль 14.4 сая төгрөгийн халаалтын зардлын өр төлбөртэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 82.0 хувьтай үнэлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,826.6	173,986.1
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,852.1	157,894.4
3	АВЛАГА	3,605.9	1,631.3
4	БАРАА МАТЕРИАЛ	17,368.7	14,460.5
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	456,877.2	483,202.9
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	456,877.2	483,202.9
7	Биет хөрөнгө	447,391.2	473,716.9
8	Биет бус хөрөнгө	9,486.0	9,486.0
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	515,703.9	657,189.0
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,090.6	19,993.3
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,090.6	19,993.3
12	Өглөг	1,090.6	19,993.3
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	514,613.3	637,195.6
14	Засгийн газрын хувь оролцоо	514,613.3	637,195.6
15	Засгийн газрын оруулсан капитал	55,518.6	55,518.6
16	Хуримтлагдсан үр дүн	426,194.1	548,776.5
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,900.5	32,900.5
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	515,703.9	657,189.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,008,854.3	644,643.5
2	ТАТВАРЫН ОРЛОГО	184,663.1	211,201.3
3	Орлогын албан татвар	183,313.5	208,243.6
4	Хувь хүний орлогын албан татвар	183,980.7	211,060.8
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(667.2)	(2,817.2)
6	Хөрөнгийн албан татвар	506.4	879.2
7	Бусад татвар, төлбөр, хураамж	843.2	2,078.5
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	251,377.0	433,442.2
9	Тусламжийн орлого	-	322,601.2
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	572,814.3	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	833,233.9	522,061.1
12	УРСГАЛ ЗАРДАЛ	833,233.9	522,061.1
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,159.3	521,211.1
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	185,140.6	207,728.7
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,580.0	27,676.6
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,899.7	126,547.0
17	Хангамж, бараа материалын зардал	18,603.1	19,542.8
18	Нормативт зардал	2,400.0	1,097.0
19	Эд хогшил, урсгал засварын зардал	16,217.6	31,083.1
20	Томилолт, зочны зардал	850.0	885.0

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,765.0	3,807.3
22	Бараа үйлчилгээний бусад зардал	94,703.3	102,843.7
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	388,074.6	850.0
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	175,620.4	122,582.4
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	175,620.4	122,582.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	338,992.8	338,992.8
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	338,992.8	338,992.8
3	Тайлант үеийн үр дүн	175,620.4	175,620.4
4	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	514,613.3	514,613.3
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	514,613.3	514,613.3
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	514,613.3	514,613.3
7	Тайлант үеийн үр дүн	122,582.4	122,582.4
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	637,195.6	637,195.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	757,677.3	533,822.5
2	ТАТВАРЫН ОРЛОГО	184,663.1	211,201.3
3	Орлогын албан татвар	183,313.5	208,243.6
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(667.2)	(2,817.2)
5	Хөрөнгийн албан татвар	506.4	879.2
6	Бусад татвар, төлбөр, хураамж	843.2	2,078.5
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	843.2	2,078.5
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200.0	322,621.2
9	Нийтлэг татварын бус орлого	200.0	20.0
10	Тусламжийн орлого	-	322,601.2
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	572,814.3	-
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	748,314.7	413,780.2
13	УРСГАЛ ЗАРДАЛ	748,314.7	413,780.2
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,240.1	412,930.2
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,617.2	207,883.3
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,580.0	27,676.6
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,563.5	113,154.4
18	Хангамж, бараа материалын зардал	22,490.8	17,567.6
19	Нормативт зардал	2,400.0	1,097.0
20	Эд хогшил, урсгал засварын зардал	17,217.6	37,234.5
21	Томилолт, зочны зардал	850.0	885.0
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,520.9	3,807.3

23	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,624.5
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	388,074.6	850.0
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,362.6	120,042.3
26	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,540.0	-
27	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,540.0	-
28	Дотоод эх үүсвэрээр	2,540.0	-
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,540.0)	-
30	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,822.6	120,042.3
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,029.4	37,852.1
32	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,852.1	157,894.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	525,744.0	531,230.5	(5,486.5)	101.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	464,091.0	211,221.3	252,869.7	45.5
320001	Орон нутгийн төсвөөс	464,091.0	211,221.3	252,869.7	45.5
34	Оны эхний үлдэгдлээс	61,653.0	-	61,653.0	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525,744.0	411,188.2	114,555.8	78.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,744.0	411,188.2	114,555.8	78.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,956.0	410,338.2	18,617.8	95.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,785.5	207,883.3	1,902.2	99.1
210101	Үндсэн цалин	96,880.4	97,140.0	(259.6)	100.3
210102	Нэмэгдэл	82,185.1	80,299.3	1,885.8	97.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,720.0	30,444.0	276.0	99.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,808.9	27,676.6	2,132.3	92.8
210201	Тэтгэврийн даатгал	21,337.5	19,205.2	2,132.3	90.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,117.9	2,117.9	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,058.9	1,058.9	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058.9	1,058.9	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,235.7	4,235.7	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,334.0	113,154.4	9,179.6	92.5
210301	Гэрэл, цахилгаан	32,000.0	27,634.6	4,365.4	86.4
210302	Түлш, халаалт	89,234.0	84,819.8	4,414.2	95.1
210303	Цэвэр, бохир ус	1,100.0	700.0	400.0	63.6
2104	Хангамж, бараа материалын зардал	18,700.0	17,567.6	1,132.4	93.9
210401	Бичиг хэрэг	1,000.0	525.0	475.0	52.5
210402	Тээвэр, шатахуун	15,000.0	14,973.6	26.4	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200.0	1,089.0	111.0	90.8
210405	Ном хэвлэл	100.0	80.0	20.0	80.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400.0	900.0	500.0	64.3

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,087.6	38,331.5	756.1	98.1
210604	Урсгал засвар	28,240.0	26,490.7	1,749.3	93.8
210502	Хоол, хүнс	-	1,097.0	(1,097.0)	
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,847.6	10,743.8	103.8	99.0
2107	Томилолт, зочны зардал	1,400.0	885.0	515.0	63.2
210702	Дотоод албан томилолт	1,400.0	885.0	515.0	63.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,820.0	1,215.3	604.7	66.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,260.0	716.4	543.6	56.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500.0	443.9	56.1	88.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60.0	55.0	5.0	91.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,020.0	3,624.5	2,395.5	60.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,020.0	3,624.5	2,395.5	60.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,788.0	850.0	95,938.0	0.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	93,788.0	-	93,788.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000.0	850.0	2,150.0	28.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	37,852.1	(37,852.1)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	157,894.4	(157,894.4)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,592.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,592.0
122	Тусламжийн орлого	2,592.0
1221	Хандив тусламж /дотоод/	2,592.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,592.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,592.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,592.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,592.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,592.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,592.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,592.0

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн байгууллага, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Захирагчийн ажлын албаны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 132.0 сая төгрөгийн мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой 2 алдааг залруулж, 1 албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 10.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 5.2 сая төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Залруулагдаагүй нийт 15.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 15.6 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15.9 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс, 2 албан шаардлага, 15.9 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.3.1 Албан шаардлага

Нэг. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 15.6 сая төгрөгийн 5 зөрчил илэрч, 10.4 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.2 сая төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Хоёр. Өмнөх аудитаар өгсөн 2023 оны 01/73, 02/73, 03/73 дугаартай төлбөрийн акт, 2025 оны 01/172, 02/172 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй үлдэгдэлтэй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

3.3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэг. Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс хадгаламж хүүгийн орлого 15.9 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны

орлогыг бүрэн төвлөрүүлэх", "Дэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 29 дүгээр тогтоол"-той нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг хангуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		(мянган төгрөг)	
Байгууллагын нэр		Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗАА	2 132,046.0	2	132,046.0	-	-	2	132,046.0	-	-
Дүн	2 132,046.0	2	132,046.0	-	-	2	132,046.0	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж		Хариуцлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1 15928.9	3	15928.9	2	-	1	15,928.9	-	-	-	-
ЗАА	1 15,623.4	5	15,623.4	1	10,392.4	1	5,230.0	1	1	1	-
Дүн	2 - 1 -	8	31,552.3	3	10,392.4	2	21,158.9	1	1	1	-

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр												
			1	2	3	4	5	7	8	9	10				
A	1														
1	ТТЗ		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвшэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтийг	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан					
	НИЙТ		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1

Үүнээс: Аудит хийсэн хэлбэр